

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

ДЭВШИЛТЭТ СЭТГҮҮЛ ЗҮЙН ТУХАЙ МАРГААН БА ГАРЦ

Н.Ариунзаяа*

*АНУ-ын Лос-Анжелес хотын Олонулсынхэлнийсургуулийн дадлагажигч, сэтгүүлзүйндоктор (Ph.D)

Түлхүүр үг: дэвшилтэт сэтгүүл зүй, олон нийтийн сэтгүүл зүй, шүхэрт сэтгүүл зүй, мэдээлэл харилцаа холбооны шинэ журам.

ХХ зууны сүүл хэрд Дорнод Европын орнуудад нийгмийн өөрчлөн байгуулалтын үзэл санаа дэлгэрч, улмаар социалист системийг толгойлж байсан ЗХУ-д хувьсгалын шинжтэй эргэлт гарч, холбооны улсууд тарж бутарснаар дэлхий ертөнц эсрэг тэсрэг хоёр системд хуваагдаж байсан цаг эцэс болсон билээ. Үр дүнд нь ардчилсан тогтолцоог эрхэмлэх үзэл санаа улс орнуудын хөгжлийн гол хандлага болсон юм. Ардчиллын амин сүнс нь олон ургальч хэвлэл мэдээлэл бөгөөд тэр нь гагцхүү олон нийтийн оролцоонд түшиглэж үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Нэгэн үе сэтгүүл зүй иргэдийн амьдралаас холдож, дэлхий дахины глобаль асуудлуудад түлхүү анхаарах болсон билээ. Ингэснээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярьж, бичиж, үзүүлж байгаа зүйл иргэдэд харь гаригийн тухай мэдээлэл мэт сэтгэгдэл

төрүүлж, өөрт нь хамааралтай зүйл хомс тул үзэх, сонсох хэрэггүй гэх хандлага давамгайлж ирсэн байна. Сэтгүүл зүйд гарсан энэ сөрөг хандлагыг ажигч, овсгоотой сэтгүүлчид соргоогоор мэдэрч сэтгүүл зүйн дэвшилтэт чиглэл болох олон нийтийн сэтгүүл зүйн хөдөлгөөнийг эхлүүлсэн юм. Уг хөдөлгөөнийг хөгжөөхөд сэтгүүл зүйг амьдралдаа ойр байлгахыг хүсч байсан иргэдийн идэвхтэй хэсэг, технологийн дэвшил гэсэн хоёр хүчин зүйл ихээхэн түлхэц болсон билээ. Анхнаасаа л сэтгүүл зүйд эерэг, сөрөг хоёр нөлөөг авч орж ирсэн дэвшилтэт сэтгүүл зүй өнөөдөр нийгмийн институт болох шатандаа шилжсэн байна.

Олон нийтийн сэтгүүл зүйн хөдөлгөөнийхний уламжлалт сэтгүүл зүйн мэдээлэл цуглуулж, бэлтгэж байгаа байдлын талаарх шүүмжлэл нь дал, наяд онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Олон улсын мэдээллийн үнэ цэнэ”-ийн зөрчилдөөний асуудлыг шийдвэрлэх форум дээр тавигдаж байсан асуудлуудын үргэлжлэл мэт байдаг. Тэр мэтгэлцээн өнөөг хүртэл тасралтгүй үргэлжилсээр байгаа юм. Ялангуяа наяд онд гарсан

“Макбрайдын тунхаг” тэрхүү маргааныг дээд цэгт нь хүргэсэн. Хачирхалтай нь Америкийн хэвлэлийнхэн “Макбрайдын тунхаг”-т дэвшүүлж тавьсан “Дэвшилтэт сэтгүүл зүй”-н үзэл баримтлалыг нэлээд олон талаар няцааснаар үл барам Америкийн хэвлэл мэдээллийн олон хэрэгсэл илэрхий эсэргүүцсэн мэдээлэл, нийтлэл гаргаж байлаа. Хэдийгээр ийм бэрхшээлтэй тулгарсаар байсан ч дээрх сэдэв өнөөдөр олон нийтийн сэтгүүл зүйн баримтлах гол зарчим болсон бөгөөд бусад улс орнуудад ч чиг баримжаа болж түгэн дэлгэрсээр байгаа билээ.

Макбрайдын тунхагийг авч хэлэлцэх болсон гол шалтгаан нь хөгжиж буй гуравдагч орнууд болон Барууны орнуудын зах зээлд тулгуурласан хэвлэлийнхний хоорон-дын зөрчлөөс үүдэлтэй юм. Гуравдагч орнууд нь Барууны мэдээллийн агентлагуудын монопольчлол болон өөрсдийнх нь асуудлыг хэрхэн мэдээлж буй байдалд гомдол гаргасан байна. Тэдний үзэж буйгаар хөгжиж буй орнуудын тухай мэдээлэл нь ядмаг, өнгөц, жигд бус байдаг гэнэ. Түүнчлэн зөвхөн хүчирхийлэл, үймээн самууныг л дэвэргэн мэдээлдэг гэсэн байна. Шуудхан хэлэхэд Барууны хэвлэл мэдээллүүд хамгийн их үймээн самуунтай, цус урсгасан орнуудыг л мэдээллийнхээ бай болгодог байна. Тэгсэн атлаа энх тайван замаар хөгжиж байгаа орнуудын талаар дуугүй өнгөрдөг аж.

Өнгөрсөн зууны далаад онд Барууны хэвлэл мэдээллийн хэрэгс-лүүдийн дан ганц сөрөг үйл явдал, зөрчилдөөнд суурилсан мэдээлэл түгээдэг явдал олон улсын хэмжээний асуудал болоод байв. Туршлагатай олон улсын сэтгүүлч Морт Роземблам “Дэлхийн мэдээллийн шинэ горим”-ын талаарх

үзэл бодлоо өөрийн номонд илэрхийлсэн. Тэрээр “Мэдээг хэн хулгайлав? Бид яагаад дэлхий дахинд болж буй үйл явдалтай хөл нийлүүлэн алхаж чадахгүй байна?” гэсэн асуултын хариуг хайсан байна. Розембламын үзэж байгаагаар дэлхий дахины их сургуулиудын эрдэмтэд болон удирдагчдыг сэтгүүл зүйд нэгтгэх болжээ. Тэд шинэ дэвшилтэт сэтгүүл зүй буюу гуравдагч орнуудын удирдагчдад тулгамдаж байгаа асуудлуудад хариу өгөхүйц сэтгүүл зүйг буй болгох арга замыг хэлэлцсэн юм.

ЮНЕСКО-гоос хоёр жил тутамд зохион байгуулдаг Найробигийн ээлжит Бага хурал дээр Орос Улс сэтгүүлчид болон тэдний мэдээллийн үйл ажиллагаанд Засгийн газрын тогтоолоор хяналт тавьж байхыг бусад орнуудад зөвлөсөн байна.

1978 онд ЮНЕСКО-гийн Ерөнхий Бага Хурлаас мэдээлэлд шинэ үнэлэмж нэвтрүүлэх, олон улсын мэдээллийн урсгалыг тэнцвэржүүлэх зорилгоор Дэлхийн Мэдээлэл, Харилцаа Холбооны Шинэ Журам (NWICO)-ыг тунхагласан юм. Энэхүү журам нь Барууны мэдээллийн хуучин үнэлэмж бага буурай орнуудын өөрийгөө тодорхойлох хийгээд үнэлэх үнэлэмжид хортой нөлөө үзүүлж байна гэж үздэг гуравдагч орнуудын гомдлыг нааштайгаар шийдвэрлэж, тэдний улс төрийн болон соёл, ёс заншлын шаардлагад нийцсэн үнэлэмж бүхий мэдээллүүдийг түлхүү түгээх бололцоог нээсэн байна.

Дэвшилтэт сэтгүүл зүйн онолоор бол гадаадын сэтгүүлчид бага буурай орнуудын сайн сайхан байдлыг өөрийн биеэр хариуцсантай адил үүрэг хүлээх ёстой юм байна. Барууны сэтгүүлчид гуравдагч орнуудын талаар аль болох эерэг мэдээллийг, аль болох томоохон

нийтлэлээр түгээх тусам тухайн орнуудын үймээн самууныг намжаахад тус болох аж. Хуучин сэтгүүл зүйн арга барил нь гуравдагч орнуудын хурц, ээдрээтэй асуудлуудыг улам дэвэргэж, тэдгээр улсуудын удирдагч нар дотоодын асуудлаа шийдвэрлэх гарц олоход нь саад болдог байв. Гэтэл шинэ дэвшилтэт сэтгүүл зүй нь эв найрамдал, хөгжил цэцэглэлтийг авчрахын төлөө байх ёстой аж. Роземблам олон улсын мэдээллийн нөхцөл байдлыг нягт нямбай судалсны эцэст Америк мэтийн өндөр хөгжилтэй орнуудын редакторууд гуравдагч орнуудын шүүмжлэлийг хурцаар тусган авч, шинэ дэвшилтэт сэтгүүл зүйн чиглэлийг аль болох баримтлах гэж оролдож эхэлснийг тэмдэглэсэн байна. Тэрээр Америкийн нэгэн редактор лекц уншихдаа хэлсэн “Хэрэв сэтгүүлч Сомалийн тухай сөрөг мэдээ бэлтгэж байгаа бол тухайн улсын ард иргэдийн бичиг үсэг тайлагдаагүй байдалтай тэмцэж байгаа кампанит ажлын тухай бичих хэрэгтэй. Нийслэл хот нь ганц ч гэрлэн дохиогүйг бичих гэж байгаа бол замын хөдөлгөөнд оролцох машин цөөтэйг ч бичих хэрэгтэй. Энэ мэтээр тухайн орны нийгэм эдийн засгийн асуудлын талаар юу өгүүлэхээ сайтар бодож тэнцвэртэй бодитой мэдээлэл түгээнэ гэсэн үг юм” гэснийг иш татжээ. Редакторын үг шинэ олон нийтийн сэтгүүл зүйн хөдөлгөөний философиог агуулжээ. Тэр нь АНУ-ын эмзэг бүлгийнхний асуудлыг хөндөхөд ч мөн хамааралтай аж. Улс орнуудын ядуу ард түмний бичиг үсэг тайлагдаагүй байдал, гэмт хэрэг, мансууруулах бодисын зүй бус хэрэглээ гэх мэт хар бараан явдлыг мэдээлээд байх нь тухайн асуудлуудыг шийдвэрлэх биш, харин ч гааруулахад хүргэдэг гэж дэвшилтэт сэтгүүлчид үзэж байна.

Түүний оронд сөрөг үйл явдал дотроос бага ч гэсэн эерэг зүйлийг олж харж, нийгэм хийгээд удирдагч нарт сонордуулснаар хөгжил дэвшил, эв найрамдлыг авчрах боломжтой гэжээ. Тэд хэвлэл мэдээллийнхэн нийгмийн хүндрэл бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэхийг эрэлхийлээс гадна гэмт хэрэг болон мансууруулах бодисын хэрэглээний тухай аймшигт түүхээр мэдээнийхээ гарчиг хийгээд сонин, сайтынхаа нүүр хуудсыг чимэхгүй байх нь эерэг үр дүн авчрах нэг нөхцөл гэж үзэж байна.

Дэвшилтэт сэтгүүл зүйн зарчим болон олон нийтийн шинэ сэтгүүл зүйн философийн чиглэл хоёрт ижил төстэй зүйл олон бий. Барууны мэдээллийн үнэлэмжийн талаар хөгжиж буй орнуудын гаргаж байсан гомдол нь Америкийн уламжлалт сэтгүүл зүйг олон нийтийн сэтгүүл зүй шүүмжилсэнтэй “агаар нэг” байна. Үүнээс дараах асуултууд урган гарч ирнэ. Юуны түрүүнд олон нийтийн сэтгүүл зүй нь өөр үгээр нэрлэгдсэн дэвшилтэт сэтгүүл зүй мөн үү? гэдэгт хариулахын тулд хэд хэдэн жишээ авах хэрэгтэй болно.

“Шүхэрт сэтгүүл зүй”.

Дэвшилтэт сэтгүүл зүйн талыг баримтлагчдын үзэж буйгаар барууны сэтгүүлчид мэдээлэл бэлтгэж байгаа орныхоо асуудлыг жинхэнэ ёсоор сонирхдоггүй, эсвэл өөрт ашиггүй гэж үздэг тул тэдний бэлтгэсэн мэдээлэл бүрэн бус, буруу зөрүү, бусад эх сурвалжаас шууд хуулсан байдаг. Тэгсэн атлаа хямрал, гамшиг зэрэг түгшүүрт явдал тохиолдсон үед зайлшгүй шаардлагатай гэж үзэн тансаг оффисоосоо яаран гарч асуудлын голомт руу нисцгээдэг. Зүйрлэн хэлбэл сэтгүүлч үйл явдлын голомтод шүхрээр бууж шаардлагатай

мэдээллээ дуртай ч, дургүй ч цуглуулж аваад соёл иргэншил рүүгээ нисээд явчихдаг.

Олон нийтийн сэтгүүл зүйн талыг баримтлагчид нь сэтгүүлчдийг судалж, сурвалжилж байгаа объектоосоо “бүрэн тусгаарлагдсан” байхаар сургадаг тогтолцоог шүүмжилдэг. Өөрөөр хэлбэл үйл явдалд хүнийссэн сэтгэлээр хандахын эсрэг байдаг. Сэтгүүлчид асуудал үүссэн газарт “шүхрээр бууж” буудалцаан, үймээн самуун, эсвэл гамшиг зовлонг хурдхан мэдээлчихээд аюулгүй, тухлаг мэдээнийхээ өрөөнд ирж илүү нэр хүндтэй мэдээллийн хэрэгсэлд шурган орох, эсвэл албан тушаал дэвших боломжийг чагнаархан суухыг илүүд үздэг. Ийм өнгөц хандлага сэтгүүлчийн илүү ихийг туурвин бүтээх хүсэл тэмүүллийг үгүй хийдэг. Ашигтай ажил, өндөр цалингийн хойноос хөөцөлдөх байдал нь олон нийтэд өгөөжгүй, асуудлыг шийдэх бус зөвхөн мэдээлээд л өнгөрөхөд болно гэсэн идэвхгүй хандлагыг бий болгодог байна.

Улс төрийн үймээн самуун болон газар хөдлөлт. Дэвшилтэт сэтгүүл зүйн талыг баримтлагчид барууны хэвлэл мэдээлэл гуравдагч орнуудын хөгжил дэвшлийн эерэг талыг бус, харин ч үймээн самуун, гамшиг зовлон, бослого хөдөлгөөн гэх мэт бараан мэдээлэлд анхаарлаа илүү хандуулдаг хэмээн буруутгаж ирсэн. Макбрайдын тунхаг ид хүчээ авч байх үед ЮНЕСКО-д Тунисийн элчин сайдаар ажиллаж байсан Мустафа Масмуди “Үндэстэн дамнасан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь хөгжиж буй орнуудыг харах өөрсдийн гэсэн өнцөгтэй байдаг. Хэрэв та тэдний үйлдлийг анхааралтай ажигласан бол хөгжиж буй орнуудыг хамгийн муу

талаас нь харуулж гамшиг осол, тэмцэл мөргөлдөөн, үймээн самуун зэрэг өлзий бус явдлыг нь илүү шохоорхож, заримдаа бүр тохуурхсан байдалтай мэдээлэл цацах нь ч бий” гэсэн билээ.

Олон нийтийн сэтгүүл зүйн талыг баримтлагчид Америкийн хэвлэл мэдээллийнхнийг улс төрийн үймээн самуун болон газар хөдлөлтийн синдромтой гэж шүүмжилдэг. Тэдний хэвлэлд сөрөг мэдээлэл бүхий гарчгууд хаа сайгүй ярайна. Тэд нийгмийн эмзэг бүлгийнхнийг зөвхөн сөрөг мэдээллийн бай болгодог. Бүтэлгүй, хүнд хэцүү асуудлууд тэдний хувьд олз омог болж, ард иргэдийн амьдралын хүчирдэл, үймээн самуун, онгоцны осол гэх мэт сэдвүүд сонин хэвлэлийн тэргүүн нүүрэнд тавигдах гайхалтай мэдээлэл болдог аж. Судлаач Мерритийн үзсэнээр жинхэнэ тэнцвэртэй мэдээний гарчиг нь “25890 онгоц аюулгүй газардаж, нэг онгоц Нью-Йорк хотод осолдов” гэсэн маягтай байх ёстой гэнэ. Иргэний сэтгүүл зүйн “Пью” төвийн судлаач Фоух ч мөн өнөөгийн байдлыг шүүмжилдэг бөгөөд “Америкийн уламжлалт мэдээллийн сөрөг чанар нь асуудлыг шийдвэрлэгдэшгүй, давагдашгүй хүчин зүйл мэтээр харагдуулдаг явдал мөн. Тэд мэдээлж буй асуудлуудыг энгийн хүний хэрээс хэтэрсэн гэтлэх аргагүй гамшиг мэт сэтгэгдлийг үзэгч, уншигчдад төрүүлж байдаг” хэмээжээ.

Капиталист үүрэг хариуцлага. Дэвшилтэт сэтгүүл зүйн талыг баримтлагчдын олонх нь төрийн өмчит болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээлэлд ажилладаггүй, зах зээлд суурилсан хэвлэл мэдээллийн орчингүй орнуудаас гаралтай хүмүүс байдаг. Тэд мэдээ, мэдээллийг

зарагдах зүйл гэхээсээ илүү олон нийтийн үзэл хандлагыг чиглүүлэх, үндэстний оюун санаа, үзэл бодлыг төлөвшүүлэхэд ашиглах хэрэгсэл гэж үздэг. Түүнчлэн тухайн мэдээлэл олон нийтэд хэрхэн нөлөөлөхийг бодохоос биш, хүмүүс ийм мэдээллийг худалдаж авах эсэхэд анхаардаггүй аж. Олон нийтийн сэт-гүүл зүйн талыг баримтлагчид ч тэдэнтэй адил зах зээлийн хүчин зүйлийг эсэргүүцэж, сенсаци болон хоосон мэдээллийн үнэлэмжийг дэлгэрүүлэхийг буруушаадаг. “Де Шарлот Обзервер”-ийн ах-лах редактор Жим Валсер “Миний бодлоор сонин ямар нэг зүйлийн төлөө тууштай зогсдог байх ёстой” гэсэн нь дээрх дүгнэлтийн жишээ болох юм. “Олон хүний хувьд сонин хэвлэл нь мөнгө сордог бас нэг аварга корпорацийн хэлбэр болж харагдах боллоо” хэмээн Жим Валсер онцолжээ. Олон нийтийн сэтгүүл зүйн талыг баримтлагчид нь өөрсдийн хөдөлгөөнийг мэдээг жинхэнээсээ хүсэн хүлээдэг хэрэг-лэгчдийг эргүүлэн татахад чиглэгдсэн үйл ажиллагаа гэж тодорхойлжээ. Тэд мөн сэтгүүл зүй нь олон нийтийн идэвхийг сэргээх, иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцдог болгоход чиглэх ёстой гэж үздэг.

Шийдлийн чиг баримжаа.
Дэвшилтэт сэтгүүл зүйн талыг

баримтлагчид нь мөргөлдөөн болон сөрөг үйл явдлуудын мэдээллийг дөвийлгөдөг барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн чиг баримжаа нь үндэстнүүдэд тулгарсан асуудлыг шийдвэрлэх гарц олоход саад тотгор болдог гэж шүүмжилдэг. Хэт бараан мэдээлэл хөгжил дэвшлийг хойш чангаадаг. Улс төрийн үүднээс авч үзвэл барууны хэвлэл мэдээллийн чиг

хандлага нь шинээр байгуулагдсан болон хэврэг засгийн газрыг тогтворгүй болгож, олон нийтийг нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн зүгт хөтлөхөд сөргөөр нөлөөлдөг байна. Олон нийтийн сэтгүүлчид сэтгүүл зүй бол асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх ёстой гэсэн үзлийг уламжлалт сэтгүүл зүйн өмнөөс сөргүүлэн тавьдаг юм.

Ардчилсан нийгэмд заавал хэрэгжүүлэх

шаардлагатай зургаан чухал чанарыг олон нийтийн сэтгүүлчид дэвшүүлэн тавьдаг. Тэр нь шударга журам, хариуцлага, энэрэл нигүүлсэл, боловсрол, хүмүүжил, тэсвэр хүлцэл болно. Эдгээрээс “тэсвэр хүлцэл” гэдэг ойлголт нь шашны номлол тул ихээхэн эсэргүүцэлтэй тулгарч жагсаалтаас хасагдсан байна. Дээрх чанарууд нь олон нийтийн сэтгүүл зүйн анхаарвал зохих асуудлуудыг тодруулж өгснөөрөө ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл эдгээр эрхэм чанарыг нийгэмд бодитой болгоход сэтгүүл зүйг чиглүүлнэ гэсэн

«

Ардчилсан нийгэмд заавал хэрэгжүүлэх шаардлагатай зургаан чухал чанарыг олон нийтийн сэтгүүлчид дэвшүүлэн тавьдаг. Тэр нь шударга журам, хариуцлага, энэрэл нигүүлсэл, боловсрол, хүмүүжил, тэсвэр хүлцэл болно. Эдгээрээс “тэсвэр хүлцэл” гэдэг ойлголт нь шашны номлол тул ихээхэн эсэргүүцэлтэй тулгарч жагсаалтаас хасагдсан байна. Дээрх чанарууд нь олон нийтийн сэтгүүл зүйн анхаарвал зохих асуудлуудыг тодруулж өгснөөрөө ач холбогдолтой юм

»

үг. Үр дүнд нь иргэдийн амьдралын чанар сайжрах учиртай.

Дэвшилтэт болон олон нийтийн сэтгүүл зүйн тухай ойлголт үүсэхдээ "Иргэний сэтгүүл зүй" гэдэг нэрээр гарч ирсэн юм. Явцын дундаас иргэнлэг, иргэний, олон нийтийн гэх мэт нэр томъёог хэрэглэх болжээ. Эдгээрээс иргэний, олон нийтийн гэдэг хоёр нэршил илүү дэлгэрсэн байна. Эрдэмтэн судлаачид энэ хоёр нэр томъёоны цаана мэдэгдэхүйц зарчмын ялгаа байна уу, эсвэл зөвхөн нэр томъёоны төдий зүйл үү? гэдэг асуудлаар өргөн маргаан өрнүүлж иржээ. Жишээлбэл Умард Каролиний их сургуулийн профессор Филипп Мейер сэтгүүл зүйн энэ шинэ чиглэлийг олон янзаар нэрлэх болсонд сэтгэл дундуур явдгаа илэрхийлээд "Олон нийтийн" гэсэн нэршлийг хүлээн зөвшөөрсөн байна. Түүний үзлээр бол шинэ чиглэлийн зорилго нь амьдралын чанарыг сайжруулах явдал аж¹. Гэтэл сэтгүүл зүйд гарсан шинэ хөдөлгөөний эхийг тавьсан "Пью" төвийн захирал Эд Фоовхи "Дэлхийн олон орноос иргэний сэтгүүл зүйг сурахаар өдий төдий сэтгүүлч ирдэг болов. Иргэний сэтгүүл зүйг дэмжигч профессорууд дэлхийн хэмжээнд хүрч очлоо"² хэмээн мэдэгдсэн байна. Өөр байр суурьтай судлаачид ч байдаг. Тухайлбал Орегоны их сургуулийн профессор Жеймс Энгелхардт олон нийтийн болон иргэний сэтгүүл зүйн ялгааг тодорхойлж "Иргэний сэтгүүл зүй сонголтод үндэслэдэг бол, олон нийтийн сэтгүүл зүй иргэдийн орлого, амьдралын хэв шинжээс ихээхэн хамаардаг"³ гэж дүгнэжээ. Тэрээр "Олон нийтийн сэтгүүл зүй нь цуглуулсан мэдээ, санал асуулгын дүнд үндэслэдэг, илүү шинжлэх ухаанч шинжтэйн дээр иргэдийн хувь нэмэрт тулгуурладаг онцлогтой. Олон нийтийн

болон иргэний сэтгүүл зүйн аль нь ч "сайн сэтгүүл зүй"-н шилдэг уламжлалыг хадгалж, шинэ зүйлээр баяжсан байдаг" гэсэн билээ. Эдгээрээс гадна олон нийтийн сэтгүүл зүй нь иргэний сэтгүүл зүйг залгаж, түүнийг илүү боловсронгуй болгон гарч ирсэн шинэ чиглэл гэж үздэг судлаачид ч байдаг.

Сэтгүүл зүй судлаачид "шинэ хөдөлгөөн" гэгддэг сэтгүүл зүйн дэвшилтэт чиглэлийн гол хоёр нэрийн тухайд нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна. Гэгээн Луйсийн чөлөөт сэтгүүл болон "Пью" төвийн иргэний сэтгүүл зүйн нийтлэлд голлох зохиогчоор оролцсон Стаси Д.Кромер шинэ хөдөлгөөнд яагаад хоёр янзын нэр зонхилох болсныг тайлбарлахдаа "Олон нийтийн сэтгүүл зүй гэдэг нэр томъёог академийнхан өргөн хэрэглэдэг бөгөөд энэ нь уг хөдөлгөөний ард буй оноц юм. Харин иргэний сэтгүүл зүй гэдэг нэрийг орон тооны биш, хувиараа ажиллагсад ихээхэн хэрэглэдэг ба энэ нэр сэтгүүл зүйн дурьдан бүхий шинэ чиглэлийг хөгжүүлэх төслийн мэдээлэлд илүү тохирдог" гэжээ. Судлаач Росеж "энэ хөдөлгөөнийг хоёр өөр сан ивээн тэтгэсэн нь хоёр өөр нэртэй болгоход хүргэсэн. Түүнээс биш энэ хоёр нэр томъёоны цаана чанарын ноцтой ялгаа байхгүй" гэж үзсэн байхад, олон нийтийн сэтгүүл зүйн нэрт онолч Жей Розен "Энэ хоёр нэрний цаана нэг нь нөгөөгөө хувааж байгаа зүйл алга"⁴ гэжээ.

Дэвшилтэт сэтгүүл зүй, түүний олон нэршлийн асуудлаар шинэ санаа дэвшүүлж байгаа судлаачид ч байна. Монголын судлаач А.Оюунгэрэл "Олон нийтийн сэтгүүл зүй нь нэгд хэвлэл мэдээллийг олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэг болгох,

хоёрт үүргээ биелүүлэхэд чиглэсэн зориудын үйл ажиллагааг зохион байгуулснаар сэтгүүлчдийг дадлагажуулах, гуравт эл хөдөлгөөнд бусад хүмүүс ба байгууллагуудыг татан оролцуулах зорилготой” гээд олон нийтийн сэтгүүл зүйгээс иргэнлэг сэтгүүл зүй үүссэн гэсэн цоо шинэ санааг дэвшүүлсэн байна. Тэрээр “Америкт эхэлсэн олон нийтийн сэтгүүл зүйн хөдлөгөөн даяаршлын ачаар бусад орнуудад хоромхон зуур нөлөөлж, нийгмийн байгуулал ямар байгаагаас үл шалтгаалан иргэд газар сайгүй идэвхжиж, хэвлэл мэдээллээр дамжуулан нийгмийн харилцаанд шууд орохыг эрмэлзэх болсноор иргэнлэг сэтгүүл зүй үүссэн”⁵ гэж үзсэн байна.

Мэдээллийн технологийн хөгжил нь иргэд өөрсдөө мэдээ мэдээлэл бүтээж сэтгүүл зүйд оролцох боломжийг олгосон. Интернет, интерактив технологи тэдэнд коммэнт бичих, вэб сайт, блог хийх, бүр цаашлаад мэдээллийн хэрэгсэлд агуулга нийлүүлэх нөхцлийг бүрдүүлсэн. Ингэснээр олон нийтийн, иргэний, иргэнлэг гэх зэрэг ямар ч нэршилтэй байгаагаас үл хамааран дэвшилтэт сэтгүүл зүй нь оролцооны (Participatory) сэтгүүл зүй болж чадсан юм. Оролцооны сэтгүүл зүйн гол ач холбогдол нь хэвлэл мэдээлэлд дутагдаж байсан олон нийтийн эрх ашгийг хамгаалахад тэднийг өргөн хэмжээнд хангалттай оролцуулж чадахгүй байсан орон зайг нөхсөн явдал мөн. Идэвхтэн бичигч (amateur), мэргэжлийн бусчууд (non-professionals), хувь нэмэр бологсод (contributors) гэх мэтээр шоолуулж гарч ирсэн тэдний бэлтгэсэн агуулгыг мэргэжлийн сэтгүүлчид дуртай ч, дургүй ч ашиглахаас өөр замгүй боллоо. Оюундаа өндөр мэдлэг

боловсролтой, гартаа компьютер, гар утас, таблеттэй тэд шинэ мэдээ ирэхийг хүлээдэг биш, харин бүтээдэг хүмүүс болж хувирсан билээ. Сэтгүүл зүй өндөр хөгжсөн Америк зэрэг орны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тэдэнд бүтээсэн агуулга болон зураг, бичлэгийн захиалга өгдөг болсон нь оролцооны дэвшилтэт сэтгүүл зүйг хүлээн зөвшөөрсний илрэл болно.

Сэтгүүл зүйг нийгмийн эрх ашгийн төлөө үйлчлүүлэх үзэл санааг гол зорилтоо болгосон олон нийтийн сэтгүүл зүйг нэг мөр хүлээн зөвшөөрч, түүний иргэд, олон нийтэд хэвлэн нийтлэх эрх чөлөөг жинхэнэ ёсоор олгож, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд тэднийг оролцуулж, мэдээллийн эргэх холбоог бий болгож, хэмжээ хүрээг өргөжүүлдэг давуу талыг ашиглах явдал нь маргааныг шийдвэрлэх цорын ганц гарц мөн.

Ишлэл

- ¹ Don H. Carrigan. 1999. The Public Journalist Movement in America. London. p.127.
- ² Don H. Carrigan. 1999. The Public Journalist Movement in America. London. p.129.
- ³ Don H. Carrigan. 1999. The Public Journalist Movement in America. London. p.131
- ⁴ Норовсүрэн Л. Энхтуяа Х. 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ., 111 дэх тал.
- ⁵ Оюунгэрэл А. “Иргэний сэтгүүл зүй ба мэргэжлийн сэтгүүл зүй”. 2016. Сэтгүүлч, сэтгүүл зүйн бүтээл. УБ., 28 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Норовсүрэн Л, Энхтуяа Х. 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ.,
2. Зулькафиль М. 1999. Сэтгүүл зүйн онолын үндэс. (Тэргүүн дэвтэр). УБ.,

3. Оюунгэрэл А. 2016. “Иргэний сэтгүүл зүй ба мэргэжлийн сэтгүүл зүй”. Сэтгүүлч, сэтгүүл зүйн бүтээл.
4. Прохоров Е.П. 1995. Введение в теорию журналистики. М.,
5. Горохов В.М. 1975. Закономерности публицистического творчества. М.,
6. Carrigan Don H.1999. The Public Journalism Movement in America. London.
7. 1998. Don't Stop There! Five Adventures in Civic Journalism. Washington.
8. Esther Thorson. 1996. Civic Lessons. Madison.
9. Hewlet J.1995. Writing for broadcast News.London-Toronto.
10. World Press Freedom Committee.1990. Handbook for Journalists of Central and Eastern Europe. Rex Pand Fund.
11. Lunt P.1993. Talk on television. London.
12. Manual for Young Journalists. 1991.
13. Stanley J. Baran, Dennis K. Davis. 2000. Mass Communication Theory. Wadsworth.
14. Merrill J. 1997. Journalism Ethics. New York.

Summary

In this article, we considered about reasons of forming advanced journalism by focusing more on global issues while leaving the issues facing to social life. The suggested solutions to deal with some problems of public and citizen journalism, which are main types of advanced journalism, were given.